



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 0/295

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 93 дугаар  
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,380,000.00 /нэг сая гурван зуун наян мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 93 дугаар цэцэрлэг /Б.Энхтуяа/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 1,380,000.00 /нэг сая гурван зуун наян мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 93 дугаар цэцэрлэг /Б.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000741

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
 даргын 2020 оны 06 дугаар сарын 29 -ны өдрийн  
 0/29 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 93 дугаар цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоохэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-ын мэргэжилт-ний дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
1	Нягтлан бодох бүртгэлийн программ	4	ш	1	480,000.00	480,000.00	480,000.00	-	шинэчлэгдэн ашиглагдахаа больсон	Актлах	Устгах	Устгах
2	Няrvын программ	4	ш	1	400,000.00	400,000.00	400,000.00	-		Актлах	Устгах	Устгах
3	Веб сайт	4	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00	-				
<b>Биет бус хөрөнгийн дүн</b>				<b>3</b>		<b>1,380,000.00</b>	<b>1,380,000.00</b>	-				
Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө								-				
<b>Актлах хөрөнгө</b>						<b>1,380,000.00</b>	<b>1,380,000.00</b>	-				